



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 7/180

Улаанбаатар хот

Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн тээврийн үйлчилгээний газар үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан хот нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх их үйл хэрэгт үнэтэй хувь нэмрээ оруулан оюун ухаанаа дайчлан ажиллаж байгаа Нийслэлийн тээврийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Батжаргалын Бадамдоржийг Хотын Ерөнхий менежерийн шагналын журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. “Өргөмжлөл”-ийг дагалдах мөнгөн шагнал болох 50,000 /тавин мянга/ төгрөгийг өөрийн байгууллагын санхүүгээс гарган урамшуулахыг байгууллагын удирдлагад мэдэгдэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



1110300570